



УУЛ УУРХАЙН ЖИШИГ СУРГУУЛЬ
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

Салбар: Уул уурхай

Мэргэжлийн индекс: 3257-22

Дипломын ажил

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
2017 ОН



УУЛ УУРХАЙН ЖИШИГ СУРГУУЛЬ
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

Салбар: Уул уурхай

Мэргэжлийн индекс: 3257-22

Дипломын ажил

Сэдэв: Нефть баазад мөрдөгдөх галын аюулгүй ажиллагаа

Гүйцэтгэсэн: *Чинзориг* ХАБЭА ЗА- ангийн оюутан Б.Чинзориг

Удирдагч:

М. Батбилэг

Ж.Батбилэг

196 А. 1

Зөвлөх багш :

А. Чулуунчимэг

Боловсролын ухааны магистр: А.Чулуунчимэг

Хамгаалалтанд орохыг зөвшөөрсөн:

Сургалтын албаны менежер:

Сургалтын арга зүйч:

Мм

Л. Ганчимэг

Ц.Мягмарсүрэн

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
2017 ОН

Агуулга

Удиртгал.....	4
---------------	---

Нэг. Хууль

1.1. ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ.....	6
1.2. Галын аюулгүй байдлын талаар ажилчин албан хаагчдын гүйцэтгэх үүрэг.....	7
1.3. Гал түймэртэй тэмцэх анхан шатны мэдлэг олгох ба зааварчилгаа өгөх журам.....	9

Хоёр. Галын аюулгүйн ерөнхий шаардлагууд, онол

2.1. Нефть баазын дэвсгэрт байгаа барилга байгууламж, усан хангамжийн очих зам, галын аюулгүйн зай хэмжээ, бүс.....	12
2.2. Гал гарахад нөлөөлөх хүчин зүйлс.....	17
2.3. Гал түймэр унтраах арга, бодис.....	21
2.4. Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл.....	29
2.5. Барилга байгууламжийн авралтын гарц.....	32

Гурав. “Петролеум Прадакшн” ХХК-ны ХАБ,ЭА-н үйл ажилгаанд хийсэн судалгаа шинжилгээ

3.1. “Петролеум Прадакшн” ХХК-ны галын аюулгүй байдал дахь ХАБ,ЭА-н бодлого.....	33
3.2. Судалгаа.....	42

Дүгнэлт:.....	49
---------------	----

Ном зүй:.....	50
---------------	----

Хавсралт:.....	51
----------------	----

Үдиртгал

Судалгааны үндэслэл: Мэдээлэл, технологийн эрин үед глобалчлал, технологийн шинэчлэл, зэрэг олон зүйлс байнгын өсөн нэмэгдэж буй зэрэг нь компаниудаас өөрсдийн давуу тал болох өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийг хором мөч бүрт шаардаж байна. Шатхуун, түлшийн төрлийн хувьд гол чиглэл нь МҮ-н хэмжээнд импортын бүтээгдэхүүнийг халж, өөрсдийн түлшийг дотооддоо нийлүүлэж ашигтай болон алдагдалгүй ажиллах байдал тул түвний дотроос хүнд нөхцөлд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын хувьд аюул, эрсдэлгүй ажиллах мөн түвнийг даван туулахын тулд хамгийн чухал арга шийдлийг олж ижил үйл ажиллагаатай байгууллагуудаас тухайн асуудлаар нэг алхам түрүүнд ажиллах нь зайлшгүй бөгөөд тогтмол ажиллах нэн түрүүний зүйл юм. Иймээс энэ байгууллагад хамгийн амархан гарж болох эрсдэл бол галын аюул болохоор галын аюулгүйн нормыг судлаж асуудлыг шийдвэрлэх зайлшгүй шаардлага байгааг төрсөлийн ажлынхаа гол үндэслэл болгосон болно

Сэдвийн судлагдсан байдал: Мэдээ мэдээллийн хувьд бичгийн ажил олдоц их байдал нь энэхүү асуудлыг судлан онол практикийг харьцуулж судалцах хэрэгтэй нь харагдаж байна.

Судалгааны зорилго: "Петролеум Прадакшн" ХХК НБҮ-ийн аюулгүй ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх талаар онол болон практикийн судалгаа хийж практикт тугамаж буй асуудлуудыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж санал зөвлөмж дэвшүүлэхэд оршино.

Судалгааны зорилт:

1. Галын аюулгүйн нормын тухай онол арга зүйг судлах
2. Байгууллагын галын аюулгүйн нормыг практик дээр судлах
3. Галын аюулгүйн нормыг оновчтой тодорхойлж, санал зөвлөмж дэвшүүлэх

Судалгааны ажлын хүрээ: Энэхүү судалгааны ажлыг нь "Петролеум Прадакшн" ХХК нефть боловсруулах үйлдвэрийн нефть баазын үйл ажиллагааны галын аюулгүйн нормыг судлах ба тус байгууллагын хамгийн энгийн буюу наад захын юм авч үзвэл

галын аюулгүйн постуудаар дамжуулан тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх талаар оновчтой санал гаргахаар хязгаарлагдана.

Шинэлэг тал: ХАБЭА-н галын аюулгүй нормын гүйцэтгэлийн төвшинг бүрэн ханган гүйцэтгэх, илүү боловсронгуй болгох тал дээр санал зөвлөмж дэвшүүлж, хэрэгжихүйц шийдлийг дэвшүүлэх нь чухал юм.

Судалгааны арга зүй: Энэхүү судалгааны ажлыг боловсруулахдаа анхдагч болон хоёрдогч мэдээлэлийг ашиглан судалгаа шинэжилгээ, нэгтгэн дүгнэх, ажиглалт, ярилцах аргыг ашиглан судалсан болно.

Судалгааны ач холбогдол: “Петролеум Прадакшн” ХХК-ны үйл ажилгааг доголдолгүй байлгах, мөн галын аюулгүй нормын бүрэн бүтэн байдал, ашиглахад хялбар, ирээдүйд илүү боловсронгуй болгохын тулд оновчтой шийдлийг бий болгоход оршиж байгаа юм.

Дипломын ажлын бүтэц: Дипломын ажил нь 3 бүлэг 10 дэд сэдэвээс бүрдэнэ.

Нэг дүгээр бүлэгт: Галын аюулгүй байдлын талаар хууль, ажилчин албан хаагчдын гүйцэтгэх үүрэг тэдгээрийн гал түймэртэй тэмцэх анхан шатны мэдлэг олгох ба зааварчилгаа өгөх журам,

Хоёрдугаар бүлэг: алын аюулгүйн ерөнхий шаардлагууд, онол

Гуравдугаар бүлэг: “Петролеум Прадакшн” ХХК-ны ХАБ,ЭА-н үйл ажилгаанд хийсэн судалгаа шинжилгээ

Нэгдүгээр бүлэг

1.1. ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

- 1.1.1. "гал түймэр" гэж хүний амь нас, эрүүл мэнд, хувь хүн болон хуулийн этгээдийн эд хөрөнгө, байгалийн баялаг, нийгэмд хохирол учруулах шаталтыг;
- 1.1.2. "гал түймрийн гамшиг" гэж объектын болон ой, хээрийн гал түймэр өргөжин дэлгэрч олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, байгалийн баялаг, эд хөрөнгө их хэмжээгээр сүйрэхэд хүргэх нөхцөл байдлыг;
- 1.1.3. "гал унтраах удирдагч" гэж гал түймэр гарсан анхны дуудлагаар гал унтраах нэгжийг удирдаж ирсэн, гал унтраах ажлыг газар дээр нь удирдан зохион байгуулах галын байгууллагын алба хаагчийг;
- 1.1.4. "галын аюулгүй байдал" гэж учирч болзошгүй гал түймрийн аюулаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө болон төр, нийгмийн ашиг сонирхлыг хамгаалсан байдлыг.
- 1.1.5. "ой, хээрийн түймрийг унтраах" гэж ой, хээрийн түймрийн үед шаталт, тархалтыг зогсооход чиглүүлэн явуулж байгаа үйл ажиллагааг. /Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./

1.2. Галын аюулгүй байдлын талаар ажигчин

албан хаагчдын гүйцэтгэх үүрэг

- 1.2.1. Энэ дүрмийг монгол улсын нутаг дэвсгэр дээрх бүх нефть бааз, агуулах, шатахуун түгээх станцад мөрдөж бүрэн хэрэгжүүлнэ.
- Нефть баазын удирдлага, инженер техникийн ажилтнууд (ИТА) түннчлэн цех, хэсэг, тасгийн удирдах ажилтан нар энэ дүрмийн шаардлагыг өөрсдөө дагаж мөрдөх үүрэгтэй дээр бусад хүмүүс хэрхэн хэрэгжүүлж байгаад хатуу хяналт тавина.
- 1.2.2. Энэ дүрмийг үндэслэн нефть бааз, агуулах, шатахуун түгээх станц бүр өөрийн ажил ажил үйлчилгээний онцлогийг харгалзан цех, резервуарын парк, насосны станц, ачих, буулгах байгууламж, үйлдвэрлэлийн салбар, нэгж, хэсэг тус бүрт тохирсон галын аюулгүйн зааварыг боловсруулж мөрдөнө.
- Үйлдвэрлэлийн цех, хэсэг, тоног төхөөрөмжийн галын аюулгүйн зааварт дараах зүйлүүд тусгагдсан байна.
- Үйлдвэрлэлийн процесс болон хэрэглэж байгаа материал, нефть бүтээгдэхүүний гал, тэсрэлтийн аюулын шинж чанар
- Ажилчдад тавих галын аюулгүйн шаардлага
- Үйлдвэрлэлийн онцгой аюултай хэсэгт ажилладаг хүмүүст тавигдах тусгай шаардлага, авах арга хэмжээ
- Аваар болон гал гарсан үед технологи, тоног төхөөрөмжийг зогсоох дараалал
- Байгууллага нутаг дэвсгэрийн эмх цэгц, барилга барууламж, галын гидрант, усан санд хүрэх зам, гарцад тавигдах шаардлага
- Ил гал гарахыг хориглосон тамхи татахыг зөвшөөрсөн байруудад тавигдах шаардлага
- Гал гарсан үед ажигчдын гүйцэтгэх үүрэг
- Гал унтраах хэрэгслийг ажиглуулах арга

оруулах зорилгоор нефть бааз бүр галын инженер техникийн комиссыг байгуулна.

1.3. Гал түймэртэй тэмцэх анхан шатны мэдлэг

олгох ба зааварчилгаа өгөх журам

1.3.1. Нефть бааз, агуулах, шатахуун түгээх станцад ажилладаг нийт ажилчд бүх цех, тоног төхөөрөмж, барилга байгууламж, нефть баазын галын аюулгүйн дүрмийг сайтар судлуулан тусгай зааварчилга өгч бэлтгэл дадлага сургалт хийгдсэн байна.

Галын аюулгүйн талаархи бэлтгэл сургалт нь анхан шатны ба давтан зааварчилга өгөх, түүнчлэн гал түймэртэй тэмцэх анхан шатны мэдлэг олгох асуудлаас бүрдэнэ.

1.3.2. Галын аюулгүйн анхан шатны зааварчилга өгөх ажлын зохион байгуулалт, нефть баазад шинээр ажилд орсон инженер техникийн ажилтан, ажилчин, албан хаагчдад галын аюулгүйн анхан шатны болон давтан зааварчилга өгөх журмыг нефть баазын даргын тушаалаар тогтооно. Энэ тушаалын дагуу ажилд орсон инженер техникийн ажилтан, ажилчин, албан хаагчид нь нефть баазын дэргэдэх гал унтраах анги, хэсэг болон мөн нефть баазын ерөнхий инженерээс галын анхан шатны зааварчилга авна. Гал унтраах анги хэсэг байхгүй нефть баазад галын анхан шатны зааварчилгыг зөвхөн нефть баазын удирдлагын бүрэлдхүүнээс тусгайлан бэлтгэгдсэн хүн өгнө. Галын анхан шатны өрөөг нефть бааз бүр дээр тусгайлан бэлтгэсэн байна. Үүнд:

- Нефть бааз, шатахуун түгээх станц, ачих буулгах байгууламж, резервуарын парк, цех, барилга байгууламж ажлын байр бүрийн галын аюулгүйн журам горимыг харуулсан үзүүлэн таниулах материал (плакат, схем, макет гэх мэт) –тай байх
- Нефть баазад ашиглагдаж байгаа галын холбоо, дохиоллын хэрэгсэл, гал унтраах анхан шатны багаж зэвсгийн болон биет эд ангиуд
- Зааварчилга өгсөний дараагаар хүн бүрийн тэдлэг дадлагыг шалгана шалгалтанд хангалтгүй дүн үзүүлсэн хүнд давтан зааварчилга өгч

оруулах зорилгоор нефть бааз бүр галын инженер техникийн комиссыг байгуулна.

1.3. Гал түймэртэй тэмцэх анхан шатны мэдлэг

олгох ба зааварчилгаа өгөх журам

1.3.1. Нефть бааз, агуулах, шатахуун түгээх станцад ажилладаг нийт ажилчд бүх цех, тоног төхөөрөмж, барилга байгууламж, нефть баазын галын аюулгүйн дүрмийг сайтар судлуулан тусгай зааварчилга өгч бэлтгэл дадлага сургалт хийгдсэн байна.

Галын аюулгүйн талаархи бэлтгэл сургалт нь анхан шатны ба давтан зааварчилга өгөх, түүнчлэн гал түймэртэй тэмцэх анхан шатны мэдлэг олгох асуудлаас бүрдэнэ.

1.3.2. Галын аюулгүйн анхан шатны зааварчилга өгөх ажлын зохион байгуулалт, нефть баазад шинээр ажилд орсон инженер техникийн ажилтан, ажилчин, албан хаагчдад галын аюулгүйн анхан шатны болон давтан зааварчилга өгөх журмыг нефть баазын даргын тушаалаар тогтооно. Энэ тушаалын дагуу ажилд орсон инженер техникийн ажилтан, ажилчин, албан хаагчид нь нефть баазын дэргэдэх гал унтраах анги, хэсэг болон мөн нефть баазын ерөнхий инженерээс галын анхан шатны зааварчилга авна. Гал унтраах анги хэсэг байхгүй нефть баазад галын анхан шатны зааварчилгыг зөвхөн нефть баазын удирдлагын бүрэлдхүүнээс тусгайлан бэлтгэгдсэн хүн өгнө. Галын анхан шатны өрөөг нефть бааз бүр дээр тусгайлан бэлтгэсэн байна. Үүнд:

- Нефть бааз, шатахуун түгээх станц, ачих буулгах байгууламж, резевуарын парк, цех, барилга байгууламж ажлын байр бүрийн галын аюулгүйн журам горимыг харуулсан үзүүлэн таниулах материал (плакат, схем, макет гэх мэт) –тай байх
- Нефть баазад ашиглагдаж байгаа галын холбоо, дохиоллын хэрэгсэл, гал унтраах анхан шатны багаж зэвсгийн болон биет эд ангиуд
- Зааварчилга өгсөний дараагаар хүн бүрийн тэдлэг дадлагыг шалгана шалгалтанд хангалтгүй дүн үзүүлсэн хүнд давтан зааварчилга өгч

заавал дахин шалгалт авч зөвхөн тэнцсэн нөхцөлд ажилд орохыг зөвшөөрнө.

1.3.3. Галын аюулгүйн давтан зааварчилга өгөх ажлын зохион байгуулалт.

- Галын аюулгүйн давтан зааварчилга нь анхан шатны зааварчилгын үргэжлэл юм. Энэхүү зааварчилга нь инженер техникийн ажилтан, ажилчин албан хаагчид өөрийн ажлын байранд үйлдвэрлэлийн технологийн процесстэй танилцаж, техникийн нэр томъёог мэдэж ажлын байраа судалсны дараагаар шууд ажлын байран дээр нь өгөгдөнө.

- Нефть баазад шинээр ажилд орж байгаа инженер техникийн ажилтан, ажилчин, албан хаагч бүр зайлшгүй танилцах шаалдлагаар үйлдвэрлэлийн технологийн процессын төвөгтэй нарийн эсэх, галын аюулын байдлыг нь харгалзан галын аюулгүйн анхан шатны давтан зааварчилга өгөх хугацаат тогтооно.

- Үйлдвэрлэлийн технологийн процесст төвөгтэй биш бол гол галын аюулгүйн анхан шатны ба давтан зааварчилгыг нэг зэрэг өгч болно. Гэхдээ анхан шатны зааварчилгыг заавал тусгайлан бэлтгэсэн байранд, давтан зааварчилгыг ажлын байранд нь өгнө.

- Нэг цехээс нөгөө цехэд, нэг ажлын байрнаас нөгөө ажлын байранд, нэг албан тушаалаас нөгөө албан тушаалд шилжиж буй хүмүүст, түүнчлэн галын аюултай байдлаарай өмнөхөөсөө ялгаатай шинэ тоног төхөөрөмж ашиглаж эхэлбэл давтан зааварчилга өгнө.
- Галын аюулгүйн давтан зааварчилгыг үйлдвэрлэлийн хэсэг цехийн дарга, нефть агуулах, шатахуун түгээх станцын дарга (эрхлэгч) механик, техник, мастер нар өгнө.

- Инженер техникийн ажилтан, ажилчин, албан хаагчдын анхан шатны болон давтан зааварчилгын дүнг тусгай журналд бичиж зааварчилга авсан хүмүүс энэ журналд гарын үсэг зурна.

1.3.4. Гал түймэртэй тэмцэх анхан шатны мэдлэг олгох ажлын зохион байгуулалт

- Гал түймэртэй тэмцэх анхан шатны мэдлэг олгох хичээлийг жилдээ нефть баазын даргын баталсан 10-аас доошгүй цагийг програмаар явуулна.
- Гал түймэртэй тэмцэх анхан шатны мэдлэг олгох хичээлийн зорилго нь галын онцгой аюултай үйлдвэрлэлийн хэсэгт ажилдаг инженер техникчид ажиглалт, ажигчин, албан хаагчдын галын техникчид мэдлэгийг дээшлүүлж, үйлдвэрлэлийн технологийн процессын онцлогоос үндэслэгдсэн, галын аюулаас урьдчилсан сэргийлэх дүрмийг тэднээр судлуулах, түвчлэн объектд байгаа гал унтраах багаж хэрэгсэлтэй нэг бүрчлэн танилцуулахад оршино.
- Гал түймэртэй тэмцэх анхан шатны мэдлэг олгох программын дагуу хийгдэж байгаа хичээлийг тусгайлан төхөөрөмжилсөн байранд түвчлэн үйлдвэрлэлийн хэсэг тоног төхөөрөмж, цех, ажлын байранд явуулна.
- Гал түймэртэй тэмцэх анхан шатны мэдлэг олгох хичээлд суусан хүмүүс нь нефть баазын удирдлагаас томилсон объектын дарга буюу ерөнхий инженер удирдсан комисст шалгалт өгнө.
- Гал түймэртэй тэмцэх анхан шатны мэдлэг олгох хичээлээр шүүлэг авсан дүнг нь хүн тус бүрээр бүртгэнэ.
- Гал түймэртэй тэмцэх анхан шатны мэдлэг олгох хичээлийн шүүлгээр тэнцээгүй хүмүүсийн галын аюул багатай хэсэгт шилжүүлэн ажиглүүлж энэхүү програмаар давтан хичээллүүлнэ

Галын аюулгүйн ерөнхий шаардлагад

Усан хангамжийн оч зам, галын аюулгүйн зай хэмжээ, бүс

2.1.1. Нефть баазын барилга, байгууламжаас зэрэгцээ орших объектууд хүртлэх галын аюулгүйн зай хэмжээ дараах байдлаар тогтооно үүнд:

галын аюулгүйн эвчлэлээр харах байдлаар тооцоо үзвэл:

Д/д	Зэрэглэлдээ орших	Зай хэмжээ, м	Зэрэглэлээр
1	Зэрэглэлдэх үйлвэрийн	100	40
2	Ой хөвч, шилмүүст ой	100	50
3	Ой хөвч, навчит ой	20	20
4	Модон материал, хүдэр өвс, сүрэл үслэл бодисын агуулах	100	50
5	Станц /Төмөр зам/	100	80
6	Салаа, төрсгөл /Төмөр зам/	80	60
7	Гол зам /Төмөр зам/	60	40
8	Орон сууц, ахуйн барилга	200	100
9	Цахилгаан дамжуулах агаарын шугам	Тулгуурын өндөрөөс 1,5 дахин	
10	Авто зам	50	30
11	Газар хороолол	500	500

Тайлбар: 1. Дээрх зай хэмжээнүүд нь барилга, байгууламжийн гадна хана, хийцийн ирмэг авто, төмөр замын далангийн ирмэг, ачих, буулгах байгууламжинд авто, төмөр цагийн тэнхлэг аливаа талбайн захаас тус тус хэмжигдэнэ.

Нефть баазын дэвсгэр газрыг дараах бүсүүдэд хувааж үзнэ. Үүнд:

I бүс – төмөр замын ачих буулгах байгууламж

II бүс – резервуарын парк

III бүс – үйлдвэрийн барилга байгууламж, нефть бүтээгдэхүүн жижиглэн тараах төхөөрөмжүүд

IV бүс – контор, үйлчилгээний барилга байгууламж

2.1.2. Нефть баазын газар нь хашаатай байх бөгөөд хашааны өндөр нь 2м-ээс багагүй, барилга байгууламжуудаас (контор үйлчилгээний барилгаас бусад) 5м-ээс багагүй зайнд байрлана.

Нефть баазын дэвсгэрт галын машинд зориулсан 2-оос доошгүй орц байвал зохино.

2.1.3. Аюулгүй байдлыг хангах зорилгоор нефть баазын дэвсгэртэх бүх зам, гарцуудыг тухай бүрт нь засварлаж бүрэн бүтэн байлгахын дээр өвлийн цагт цасыг нь цэвэрлэж, шөнийн цагт гэрэлтүүлэгтэй байлгана.

2.1.4. Засвар хийх зорилгоор зам гарцыг зарим нэг хэсэгт нь хаах болбол энэ тухайгаа нефть баазын гал унтраах анги, хэсэгтэй зөвшөөрөлцөнө. Зам дээр засварын болон бусад ажлыг гүйцэтгэхдээ замын урсгалд 3,5м-ээс багагүй өргөнтэй гарц гаргах ба ухсан нүх шуудуун дээгүүр түр гүүр тавина.

2.1.5. Зам, гарц, барилга байгууламжуудын хоорондох талын аюулгүйн зайг хааж таглах, материал, тоног төхөөрөмж болон бусад зүйлийг хурааж хадгалахыг хориглоно. Зөвхөн IV бүсийн чөлөөтэй талбайд түр хугацаагаар ямар нэг зүйлийг хадгалж болох юм. Материал тоног төхөөрөмжийг барилга байгууламжийн хананд 15м-ээс багагүй зайнд зөвхөн штабельдан хурааж хадгална.

багагүй занд тарьж суулгахыг зөвшөөрнө.

Нефть баазын дэвсгэрт (I-III бүст) оч барилггүй техник явахыг хориглоно.

Нефть баазын дэвсгэрийн шатамхай уур, хий хуримтлагдаж болох

ТЭМДЭГ ТАВЬСАН БАЙНА.

Нефть баазын дэвсгэртэй хол, хаягдал, хуурай өвс, навч, үйлдвэрлэлийн

Зуны цагт өвс ургамлыг хадан авч хатаагүй байхад нь нефть баазын

хатаах, хатгалгахыг хатуу хориглоно. Нөфр баазын үйлвэрлэлийн хэсгийн

асгасан тохиолдолд үг газарыг нэн даруй цэвэрлэж элс асгана.

сувар, үндэвэрлэлийн гадна шүлэм сүлжээ болон бусад шатах уур, хий

хэрэглэхийг хатуу (дэн, кэросин, лаа, шүдэнз) хориглоно.

Тохиолдолд, түүнчлэн тэсрэлтийн аюултай байр, аппарат хэрэгслийн түр

[illegible]

index.

татахыг хориглоно. Үү бусад тусгайлан бэлтгэсэн (гал унтраах анги, хэсгийн

ХЭМЖЭЭНД БАЙРЛАНА. ҮҮНД:

Заним.

- Нефть бүтээгдэхүүн шахдаг насосны барилга, үйлдвэрлэлийн бохирын насосны барилга, резервуарын парк, резервуараас 40м-ээс багагүй зайнд.
- Ил нефть ловушка, хаалтуутын узель, нефть бүтээгдэхүүн, хий шүүрч гоождог газраас 50м-ээс багагүй зайнд.
- Нефть бүтээгдэхүүнийг ачиж буулгах төмөр замын ба авто эстакал, нефть бүтээгдэхүүн жижиглэн савлах, түгээх байрнаас 100м-ээс багагүй зайнд байрлана.

Тамхи татахыг зөвшөөрсөн газарт << Тамхи татах байр >> хорин хориглосон газарт << Тамхи татахыг хориглоно >> санамж байрлуулна.

2.1.12. Нефть баазын дэвсгэр дэхь нефть бүтээгдэхүүний уур хуримтлагдаж болох газарууд болон үйлдвэрлэлийн байранд ажил гүйцэтгэхдээ гангаар хийсэн багаж хэрэглэхийг хориглоно.

2.1.13. Нефть баазын III ба IV бүсдэх зай, чөлөөтэй талбайг барилга угсралтын түр байр, агуулах байгууламж байгуулахдаа зөвхөн нефть баазын дэргэдэх гал унтраах анги, хэсэгтэй зөвшөөрөлцсөний үндсэн дээр гүйцэтгэнэ.

2.1.14. Галын гидрант, тоног төхөөрөмжид очих зам, гарц ямагт чөлөөтэй байх ба галын гидрант, усан сангийн дэргэд тэдгээрийг түргэн олоход зориулагдсан заалт, тэмдэг тавьсан байна.

2.1.15. Өвлийн улиралд галын усан сан гидрантыг хөлдөхөөс хамгаалж дулаалах тагний мөсийг тогтмол цэвэрлэж байна.

2.1.16. Хавар, намар улиралд галын гидрант, барилгын доторх ба гадна байрлагдсан крантуудыг ус шахаж шалгана.

2.1.17. Галын тоног төхөөрөмж багаж хэрэгслийг аж ахуйн зориулалтаар ашиглахыг хатуу хориглоно.

2.1.18. Нефть баазын усны насосны станцын галын бүх насосууд нь ашиглахад байнга бэлэн байдалд байх ба галын насос тус бүрийг 10 хоног тутамд нэгээс доошгүй удаа бүрэн хүчин чадлаар нь 30 минутаас доошгүй хугацаагаар ажиллуулж шалгана.

Шалгалтын дүнг тусгай журналд хөтлөнө.

2.1.19. Галын усны насосны ерөөнд нефть баазын галын усны хангамжийн ерөнхий схем, насоснуудыг ашиглах, ажиглуулах зааварыг байрлуулсан байна. Ерөнхий схемд галын усны дамжуулах шугам холонд тахигдсан хаалтуудын байрлалыг тусгай заалтаар тэмдэглэсэн байна. Насосны стандартын найдвартай ажиглагаанд байнгын техникийн хяналт тавьж байна.

2.1.20. Нефть баазын дэвсгэр болон түүний ойр орчимд байгалийн усны эх булаг (гол, мөрөн, нуур, цөөрөм) байгаа тохиолдолд тэдгээрт очих замыг засаж жилийн аль ч улиралд ус авах боломжтой хэрэгсэл, галын машин зогсоох хийсэн байна.

2.1.21. Ой бүхий газар байрладаг нефть баазын дэвсгэрийн эргэн тойронд навчит модын 20м радиусын дотор шилмүүст модын 50м радиусын дотор тус тус цэвэрлэж зайлуулсан байна.

Ойд болон хээрийн бүсэд байрладаг нефть баазын дэвсгэрийн эргэн тойронд 2м-ээс доошгүй ергөнтэй эрсдэлжүүлсэн зурвас татна.

Нефть баазын дэвсгэрт хуурай өвс шарилж байлгахын хориглоно.

2.2. Гал гарахад нөлөөлөх хүчин зүйл



Пийшин зуухны яндангийн цоно
Санамсар болгоомжгүй байдлаа
Цахилгаан угсралтын буруугаас
Цахилгаан хэрэгсэлээ залгаатай
орхисноос



Байгалийн хүчин зүйлсийн нөлөөгөөр
Машин техникийн яндангийн очноос
Ой хээрт аялагчдын болгоомжгүй
үйлдлээс



Ерөнхийдөө дээрх гурван зүйл бүрдсэнээс үүдэн гал гарах боломжтой.

Шатдаг бодис, материал гэдэг нь ердийн нөхцөлд галын (асаах) эх үүсвэрийг ойртуулахад асаж, холдуулахад өөрөө бие даан шатах чадвартай бодис, материал. Галын шаталтын үе шатанд зөвхөн шатдаг бодис, материал оролцоно. Тэсвэрлэн шатдаг болон шатдаггүй бодис, материал галын шаталтын үе шатанд оролцохгүй.

Асаах эх үүсвэр нь үндсэн 2 төрөлд ангилагддаг. Үүнд:

Ил ба далд

Ил асаах эх үүсвэрт оч, дөл, цахилгаан нум, улайдсан биет, гэрлийн цацраг хамаарагдана.

Далд асаах эх үүсвэрт химийн урвалаас ялгарах дулаан, адсорбци, микробиологийн экзотермийн процесс, механик үйлчлэл хамаарагдана.

Исэлдүүлэгч бодис гэдэг нь исэлдэх процесс явагдах идэвхитэй орчинг үүсгэх, исэлдэх процессийг дэмжих, үргэлжлүүлэх чадвартай бодис. Агаар болон түүнд агуулагдах хүчилтөрөгч нь "хүчтэй" исэлдүүлэгчид тооцогдох бөгөөд цэвэр хүчилтөрөгчийн (O_2) хольцтой нөхцөлд шаталт хамгийн идэвхтэй явагдана. Хүчилтөрөгчийн орц 14-15 % хүртэл багасахад шаталт зогсоно. Исэлдүүлэгч нь зөвхөн хүчилтөрөгч байх биш хлор (Cl), фтор (F), хүхэр (S), мөн хүчилтөрөгч агуулсан бодисууд орно.

ГАЛ ТҮЙМРИЙН АЮУЛТАЙ ХҮЧИН ЗҮЙЛС

Хүний эрүүл мэнд, амь насанд аюул учруулах, эд хөрөнгийн хохирол үүсгэх гал түймрийн аюултай үндсэн хүчин зүйлст дараахь нөлөөллүүд хамаарагдана, Үүнд:

- Галын дөл ба оч.
- Дулааны урсгал.
- Хүрээлэн буй орчны хэт өндөр температур.
- Шаталтын ба дулааны задралын хортой бүтээгдэхүүний хэт өндөр агууламж.
- Агаар дахь хүчилтөрөгчийн хэт бага агууламж.
- Утаан дахь харагдах орчны хязгаарлалт.

Гал түймрийн аюултай үндсэн хүчин зүйлээс гадна тэдгээрийн хоёрдогч нөлөөллүүд нь мөн хүний эрүүл мэнд, амь насанд нь аюул учруулж болзошгүй, үүнд:

- Хийц бүтээцээ алдаж нурсан барилга байгууламж, авто тээврийн хэрэгсэл, технологийн байгууламж, тоног төхөөрөмж бүтээгдэхүүн болон бусад эд зүйлсийн тасархай, хэсгүүд.
- Битүүмжлэл нь алдагдсан технологийн байгууламж, тоног төхөөрөмжөөс ялгаран хүрээлж буй орчинд тархсан материал болон хорт бодис.
- Гэмтсэн технологийн байгууламж, тоног төхөөрөмжийн цахилгаан гүйдэл дамжуулах хэсэг дээр үүссэн өндөр хүчдэл.
- Гал түймрийн улмаас үүдсэн тэсрэлт дэлбэрэлтийн аюултай хүчин зүйлс.
- Гал унтраах бодисын нөлөөлөл.

ГАЛ ТҮЙМРИЙН АНГИЛАЛ

Шатаж буй бодис, материалын төрлөөс хамааруулан гал түймрийг дараахь байдлаар ангилдаг. Үүнд :

А ангиллын буюу хатуу бодисын гал түймэр

Энэхүү ангиллын гал түймэр нь үндсэн 2 дэд бүлэгт ангилагддаг. Үүнд:

A1 – шаталтын явцад уугиж шатдаг хатуу бодис, материал (мод, цаас, нүүрс)-ын гал түймэр.

A2 – шаталтын явцад уугиж шатдаггүй хатуу бодис, материал (каучук, пластмасс)-ын гал түймэр.

В ангиллын буюу шингэн бодисын гал түймэр

Энэхүү ангиллын гал түймэр нь үндсэн 2 дэд бүлэгт ангилагддаг. Үүнд:

B1 – усанд уусдаггүй шингэн бодис (бензин, эфир, нефтийн бүтээгдэхүүн)-ийн ба шингэрдэг хатуу бодис (парафин)-ийн гал түймэр.

B2 – усанд уусдаг шингэн бодис (спирт, ацетон, глицерин)-ийн гал түймэр.

С ангиллын буюу хийн бодисын гал түймэр

Үүнд ахуйн зориулалтын хий (метан), пропан, аммиак, устөрөгч болон бусад хийн төлөв байдал бүхий бодисууд хамаарагдана.

Д ангиллын буюу металл ба металл агуулсан бодисын гал түймэр

Энэхүү ангиллын гал түймэр нь үндсэн 3 дэд бүлэгт ангилагддаг. Үүнд:

D1 – хөнгөн металл (хөнгөн цагаан, магни) ба тэдгээрийн хайлшийн гал түймэр (шүлтлэг металл хамаарагдахгүй).

D2 – шүлтлэг (натрий, калий) болон тэдгээртэй адилтгах металлын гал түймэр.

D3 – металл агуулсан бодис (металл органик бодис, металлын гидрид)-ийн гал түймэр.

2.3. ГАЛ ТҮЙМРИЙГ УНТРААХ АРГА, БОДИС

Гал түймрийг унтраах арга гэдэг нь гал түймрийг унтраахад чиглэгдсэн арга хэмжээг гүйцэтгэх онцлог, төрөл юм.


Гал унтраах арга нь үндсэн төрөл байдаг. Үүнд:

- Хөргөөх арга.
- Тусгаарлах арга.
- Найруулах арга.
- Шаталтын урвалыг химийн аргаар зогсоох арга.
- Гадаргуугаар буюу талбайгаар унтраах арга.
- Эзэлхүүнээр унтраах арга.

Гал унтраах бодис гэдэг нь шаталтыг удаашруулж, таслан зогсоох үйлчилгээтэй, энэхүү процессийг бий болгох нөхцлийг бүрдүүлэх чадвартай бодис, материал юм. Гал унтраах бодис нь хатуу, шингэн ба хийн төлөв байдалтай байдаг ба унтраах аргаас хамаарч төрөл бүрийн үйлчилгээтэй байна.

ГАЛ УНТРААХ БОДИС

Гал түймрийн ангиллаас хамааран ашиглах боломжтой гал унтраах бодисын ангиллыг доорх хүснэгтэнд харуулав:

ГАЛ ТҮЙМРИЙН ТЭМДЭГ	ГАЛ ТҮЙМРИЙН АНГИЛАЛ						
		УС	ХӨӨС	НҮҮРС- ХҮЧЛИЙН Н ХИЙН	НУНТАГ	Шиддэг шингэн	Механик нунтаг
A 	ХАТУУ БОДИСЫН ГАЛ ТҮЙМЭР	✓	✓	✓	✓	✓	✓
B 	ШИНГЭН БОДИСЫН ГАЛ ТҮЙМЭР	✗	✓	✗	✓	✓	✓
C 	ХИЙН БОДИСЫН ГАЛ ТҮЙМЭР	✗	✗	✗	✓	✓	✓

ГАЛ ТҮЙМРИЙ Н ТЭМДЭГ	ГАЛ ТҮЙМРИЙН АНГИЛАЛ						
		УС	ХӨӨС	НҮҮРС- ХҮЧЛИЙН ХИЙН	НУНТАГ	Шиддэг шингэн	Механик нунтаг
 D	МЕТАЛЛ БА МЕТАЛЛ АГУУЛСАН БОДИСЫН ГАЛ ТҮЙМЭР	✗	✗	✗	✓	✓	✓
 E	ХҮЧДЭЛТЭЙ ЦАХИЛГААН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИД ГАРСАН ГАЛ ТҮЙМЭР	✗	✗	✓	✓	✓	✓
	ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД ГАРСАН ГАЛ ТҮЙМЭР	✗	✓	✓	✓	✓	

Шиддэг гал унтраагуур



ЦААСАН ХАЙРЦАГ

- Тавиурт тавихад тохиромжтой
- Хэрэглэх заавартай нь богино хугацаанд танилцах боломжтой

ХӨӨСӨНЦӨР ХАЙРЦАГ

- Гадны нөлөөнөөс хамгаалах
- Гадны өндөр температураас бүрэн хамгаалагдсан

САВХИН УУТ

- Хөөсөнцөр хайрцагыг гадны нөлөөнөөс хамгаалах
- Авч явахад авсаархан, өлгөх боломжтой

Шиддэг гал унтраагуураар А, В болон С ангиллын галыг унтраахад нэн тохиромжтой. Цельсийн -40-өөс -110 градуст тэсвэртэй бөгөөд ямар нэгэн хурц үнэргүй!
Үндсэн суурь зарчим:

Гал унтраах шингэн бодис асгарч, агаарт тархаснаар богино хугацаанд хүчилтөрөгчийг тусгаарлаж галыг унтраахын тулд маш шингэн, хөнгөн хөөс ялгаруулдаг.

Хөөсөөр гал унтраах системийн онцлог

1. Нефть бааз болон резервуарын паркийн агуулахуудад гарсан газлын өндөр, дунд болон нам өсөлтийн агаар механикийн хөөсөөр унтраахаар төлөвлөнө. Дунд давтамжийн хөөсийг ямар ч тохиолдолд хэрэглэж болно. Газар дээрх босоо резервуарын (тос болон мазут хадгалах зориулалттайгаас бусад) газлын хөдөлгөөнд техник хэрэгсэлээр унтраахаар төлөвлөсөн тохиолдолд "үе дээрхи" аргаар нам өсөлтийн хөөсийг ашиглахыг зөвшөөрнө. 2. Гал унтраахад шаардагдах хөөс үүсгэгчийн уусмал, ус болон хөөс үүсгэгчийн тооцооны зарцуулалтын хэмжээг тооцоходоо нэг дүгээр хүснэгтэд заасан тооцооны 1 м^2 гал унтраах талбай тутамд ноогдох хөөс үүсгэгчийн уусмалыг шахах эрчимд үндэслэнэ.
 3. Гал унтраахад шаардагдах тооцооны хугацаат хөөсний автомат систем – 10мин, газлын хөдөлгөөнт техник – 15мин-аар тооцно.
 4. Гал унтраах байнгын системийн инерцийн чанар гурван минутаас илүүгүй байна.
 5. Хөөс үүсгэгчийн уусмал бэлтгэхэд зориулсан ус нь газрын тос, газрын тосны бүтээгдэхүүнийн хольцыг байна.
 6. Гидравликийн тооцоо хийх үед хөөс үүсгэгчийн зунгалат чанарын нөлөөллийг тусгана.
- Хөөс үүсгэгчийн усан дахь ажлын хольцын харьцуулалтыг дараах томъёогоор олно. Үүнд:
- $$100Q_n/(Q-Q_n) = X \pm 1,$$
- Q_n - хөөс үүсгэгчийн зарцуулалт л/с
 Q – төхөөрөмжийн хүчин чадал л/с
 X – хөөс үүсгэгчийн ажлын агууламж, %

Хөөс үүсгэгчүүдийг төрөл, тэдгээрийн үзүүлэлтүүд

№	үзүүлэлтүүд	Хөөс үүсгэгчүүд								
		Ерөнхий зориулалтын						Тодорхой зориулалтын		
		ПО-1	ПО-2Д	ПО-6К	По-ЗАИ	ТАЭС	САМПО	Подслойный	форэтол	Универсальный
1	Уусмалын биологийн зардлын үзүүлэлтүүд	б/ж	б/ж	б/ж	б/м	б/м	б/м	б/ж	б/ж	б/ж
2	20 ⁰ с-ийн кинематик зунгааралдлага v , $v \times 10^{-6} \text{ м}^2/\text{с}$, илүүгүй	40	40	40	10	40	100	150	50	100
3	20 ⁰ с-ийн нягт ρ , $\rho v \times 10^3 \text{ кг/м}^3$	1.10	1.05	1.05	1.02	1.00	1.01	1.10	1.10	1.30
4	Царцах температур, C , ихгүй	-8	-3	-3	-3	-8	-10	-40	-5	-10
5	Ажлын агууламж %, усны хатуулгаас хамаарч									
	10мг- экв/л хүртэл	6	6	6	4	6	6	6	6	6
	10-30мг- экв/л	9	9	9	6	6	6	6	6	6
	30 болон их, далайн ус	12	12	12	9	9	хориглоно			
6	20 ⁰ с-т хадгалах хугацаа, багагүй жил,	5	5	5	4	5	5	3	3	3

7. Гал унтраах системд хөөс үүсгэх зориулалтаар доорхи төрлийн хөөсний генераторуудыг ашигладаг.
 - ГСС-ердийн дээвэртэй болон хөвүүр бүхий резервуарт гарсан галыг унтраах:
 - ГТС-хөвдөг дээвэртэй резервуар болон өрөө тасалгаанд гарсан галыг унтраах
 - Сорилт, түршилтанд хамрагдсан, ашиглахыг зохих журмын дагуу зөвшөөрсөн бусад төрлийн хөөсний хошуунуудыг ашиглаж болно
8. Суурилуулах хөөсний генераторт тоот тодорхойлохдоо, ашиглаж буй хөөсний хошууны дундаж бүтээмжээр хөөс үүсгэгчийн уусмалын тооцооны зарцуулалтыг тооцож их тал уруу бүхэлчилнэ.

- Нэг резервуарт хоёрдоошгүй хөөсний хошуу байх ёстой. Хөөсний хошуунуудыг приметрийн дагуу жигд зайтайгаар байрлуулна. Хөвдөг дээвэртэй резервуарын хөөсний генераторуудын хоорондын зай приметрийн дагуу 25м-ээс илүүгүй байна.

9. Хөөс үүсгэгч болон уусмалын зориулалттай усны нөөцийн (нэг тал түймэрт зарцуулагдах) хэмжээг тогтоохдоо суурилуулсан хөөсний генераторуудын хүчин чадлын дээд хэмжээ, гал унтраах тооцооны хугацаагаар тооцно.
 - Хөөс үүсгэгч болон уусмалын зориулалттай усны хадгалагдах нөөцийн нормыг тогтоохдоо нэг удаагийн гал түймэрт шаардагдах уусмалын хэмжээг (гал унтраах байнгын төхөөрөмжийн уусмалын хоолойннуудыг дүүрэн байх нөхцөлд) гурав дахин өсгөж авна.
10. Хөөс үүсгэгчийг зориулалтын дагуу чанарыг алдагдуулахгүйгээр хадгалах бөгөөд өвлийн улиралд хөлдөхөөс хамгаалах арга хэмжээ авна.

Хөөс үүсгэгчийн нөөцийг хоёрдоошгүй саванд хадгалаана. 10м^3 буюу бага Хэмжээтэй хөөс үүсгэгчийн нөөц хадгалах тохиолдолд нэг сав байхыг зөвшөөрнө. 10м^3 -аас дээш хэмжээтэй хөөс үүсгэгчийн нөөц хадгалах тус бүр

10м³-аас бага багтаамжийн тасалгаанууд бүхий нэг сав ашиглахыг зөвшөөрнө.

11. Гал унтраах суурин төхөөрөмжийн сүлжээний даралт гал түймрийн үед 60м (усны бага)-ээс багагүй, ГПС, ГПС, ГПС маркын хөөсний генераторуудын оролтод 40м (усны бага)-ээс багагүй байна.

12. Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулахад автомат болон автомат Бүс суурин систем зэрэг ашиглах тохиолдолд ерөнхий насос станц, уусмалын хоолой сүлжээ төлөвлөнө.

13. Резерварын парк, төмөр замын хоёр талт ачиж буулах байгууламжид гарсан галыг унтраах зориулалтын усны болон уусмалын хоолой сүлжээ (байнгын дүүргэлттэй буюу хуурай) битүү хүрээ хэлбэрээр, барилга байгууламж (мөн гал унтраах автомат төхөөрөмжөөр тоноглогдсон резервуарт) салаалсан оруулалттайгаар төлөвлөнө. Сүлжээ резерварын паркын гадна далангийн (хязгаарлах хана) гадна талд, ачиж буулах байгууламжийн төмөр замаас 10м-ээс багагүй зайд байрлуулна. 500 м³ болон дээш багтаамжийн газар дээрх резервар болон уусмалын хоолой хүрээнээс 200 м-ээс хол орших барилга байгууламжид тус бүр хоёр салаа оруулга төлөвлөнө. Салаалсан оруулгууд хоолойн хүрээний өөр өөр газраас холбогдсон бүрэн хангахуйц байна. Салаалсан хоолойн урт 250 м-ээс ихгүй байна. Уусмалын хоолойг галны гидрантын нэгдсэн худгудтайгаар төлөвлөх зүйтээ.

14. Худалт хөрсний ус орох магадлалтай нөхцөлд цахилгаан хаах хэрэгсэл ашиглаж байгаа тохиолдолд хөдөлгүүрийг газрын түвшнээс дээр өндөрт байрлуулсан хамгаалалтын бүрхүүл хийнэ.


Хүйтэн нөхцөлд ашиглах цахилгаан хөдөлгүүр бүхий хаах хэрэгслийг дулаан орчинд байрлуулна.


2.4. Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл

Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл гэж гал үүсвэрлэн гарсан эхэн үед шаталтыг зогсоох зориулалт/таар хэрэглэх, ямар ч хүн ажиглуулах боломжтой дараах төрлийн багаж хэрэгслийг хэлнэ. Үүнд:



1. Хүрз
2. Галын дэгээ
3. Хөрөө
4. Сүх
5. Хувин
6. Жоотуу
7. Элстэй сав
8. Устай сав
9. Эсий болон галд тэсвэртэй бүтээлэг
10. Төрөл бүрийн гал унтраагуур

MNS 5566-2005 стандарт
(Аж ахуйн нэгж байгууллагад
зайлшгүй байх шаардлагатай гал
унтраах анхан шатны багаж
хэрэгслийн норм)






Объектыг гал түймрээс хамгаалах хэрэгсэл



2.5. Барилга байгууламжийн аваргын гарц

Үчирч болзошгүй гал түймрийн аюулаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчин болон нийтийн ашиг сонирхлыг хамгаалсан байдлыг хангаж байх.



Гуравдугаар бүлэг: “Петролеум Прадакшн” ХХК-ны ХАБЭА-н үйл ажилгаанд хийсэн судалгаа шинжилгээ

3.1. “Петролеум Прадакшн” ХХК-ны галын аюулгүй байдал дахь ХАБ,ЭА-н бодлого

“Петролеум Продакшн” ХХК нь анх Монгол-Киргизийн хамтарсан хөрөнгө оруулалтайгаар байгуулагдаж 1999 онд бүртгэгдэн тус ондоо Киргиз – Америкийн хамтарсан “Key Industry Engineering Ltd” компанид хөнгөн нефть бүтээгдэхүүн боловсруулах СНП50М төхөөрөмжийн төслийг захиалж хийлгэсэн.

Төхөөмжийн угсралтыг Эрдэнэт хотод нефть баазын талбай дээр гүйцэтгэхээр шийдвэрлэсэн. Байгууламжийг барих цэгийг дараах байдлуудаас үүдэн сонгожээ:

Үйлдвэрийг 2000 оны 3 сараас эхлэн монтажлаж 2001 оны 5 сард дуусган, туршилт тохируулгын ажлуудаа хийсний дараагаар 2001 Улсын комисст хүлээлгэн өгсөн.

2000 онд “Иркутская Нефтяная Компания”-тай хийн конденсат нийлүүлэх гэрээ байгуулсан. “ИНК” компаний хийн конденсатаас гадна Уренгой, Сургут зэрэг ордуудаас түүхий эд боловсруулж нийт 60000 гаруй тонн хийн конденсат боловсруулж бүс нутгийн хэрэгцээнд хямд үнэтэйгээр нийлүүлсэн байна.


2007 онд үйлдвэрийн хувьцааг дотоодын хөрөнгө оруулагч худалдан авснаар тус компани нь 100 хувь дотоодын хөрөнгө оруулалттай болж үйлдвэрийн бүрэн хэмжээний засвар үйлчилгээ хийсэн.

Тус үйлдвэр санхүүгийн болон эдийн засгийн байдлаас тогтвортой үйлдвэрлэл эрхлээгүй ч өнөөдрийн байдлаар 2011 оноос хойш нийт 70000 тн түүхий эд боловсруулж зах зээлд бүтээгдэхүүнээ нийлүүлсэн болно.

Нефть бааз дээр аваарын байдал**тогтоосон үед авах арга хэмжээ**

1. Резервуарын парк, ачиж буулгах байгууламж технологийн шугам хоолой, бусад тоног төхөөрөмжинд гал түймэр, тэсрэх, дэлбэрэх аюул үүссэн тохиолдолд цехийн дарга, эсвэл тухайн хэсгийг хариуцсан хүн уг цех хэсэг (хэрэв зайлшгүй шаардлагатай гэж үзвэл) нефть баазын хэмжээнд аваарын байдал зарлаж энэ тухай нефть баазын удирдлагат яаралтай мэдэгдэнэ.
2. Гал унтраах, аваар осолыг арилгах ажлын зөв шуурхай зохион байгуулахын тулд нефть бааз бүрт гал унтраах анги, хэсэгтэй хамтран аваар осолыг арилгах төлөвлөгөө, гал унтраах шуурхай төлөвлөгөөг тус тус болосруулсан байх ёстой. Эдгээр төлөвлөгөөнд нефть баазын бүх албад, түүнчлэн хот дүүрэг холбогдох албадыг аваарын ажилд татан оруулах, цех хэсгийн ажлыг зогсоох дэс дараалал, хүмүүс болон тоног төхөөрөмж, материал, үнэт зүйлийг авах ажиллагааг явуулах, гал унтраах ангитай хамтран ажиллах журмыг тусгана.
Төлөвлөгөөн нефть баазын даргаар батлагдсан байна.
3. Аваарт орсон буюу түүнд холбогдох бүх тоног төхөөрөмж шугам хоолойг маш нарийн шалгаж агаарын бохирдолтын хэмжээг лабораторын шинжилгээгээр тодорхойлон өрөө, тасалгааг агааржуулсаны дараагаар аваарын байдлыг хүчингүй болгоно.
4. Аваарын байдлыг хүчингүй болгож хэвийн ажиллагааг явуулах зөвшөөрлийг нефть баазын дарга эсвэл ерөнхий инженер өгнө. Гал гарсан бол аваарын байдал тогтоосон үед галын байгуулга, инженер техникийн ажилчдын хамтран ажиллах журмыг тогтооно.

НЕФТЬ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙГ ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРЛАН МЭДЭЭЛЭХ, ДАМЖУУЛАХ АЖЛЫН БҮДҮҮВЧ



Хавсралт:

1. ГАЛ ТҮЙМЭР ГАРСАН ҮЕД ЭД ХӨРӨНГИЙГ ЗӨӨВӨРЛӨХ, ХҮМҮҮСИЙГ АВРАХ СХЕМ НАСОСНЫ СТАНЦИ
2. ГАЛ ТҮЙМЭР ГАРСАН ҮЕД ЭД ХӨРӨНГИЙГ ЗӨӨВӨРЛӨХ, ХҮМҮҮСИЙГ АВРАХ СХЕМ ТЕХНОЛОГИЙН БАЙР
3. ГАЛ ТҮЙМЭР ГАРСАН ҮЕД ЭД ХӨРӨНГИЙГ ЗӨӨВӨРЛӨХ, ХҮМҮҮСИЙГ АВРАХ СХЕМ 3-Н ДАВХАР оффис КОНТАРЫН БАЙР

Галын сайн дурын бүлгэмийн / ТСДБ / гишүүдийн гүйцэтгэх үүрэг

№	Гишүүд	Албан тушаал	Гал гарсан үед гишүүдийн гүйцэтгэх үүрэг	Галын аюулаас урьдчилсан сэргийлэх
1	Штабын дарга	Ашиглалтын инженер	Гал унтраах анти иртэл галыг унтраах ажлыг удирдан зохион байгуулах	Ажилчдад техниккийн аюулгүйн дүрэм заавар хэрхэн хэрэгжиж байгааг хяналт тавих.
2	Холбоо зарлан мэдээлэл, сурталчилгаа хариуцсан туслах. ТСДБ –н гишүүн.	Цахилгааны инженер Нарийн бичиг	Гал гарсан тухай ОБЕГ-н 7035101 УБЭУ-н 71101 УБЭУ-н ерөнхий диспетчир 71101 гэсэн дугаарын утсаар мэдэгдэж, гал гарсан газрын байршилч тодорхой зааж өгөх утгаж авах. Цахилгаан дулаан сантехник, аваарын бүлгийн гишүүдийг удирдан ажиллах	Цахилгааны аюулгүй байдалд хяналт тавих Штабын даргад илэрсэн нөхцөл байдалыг мэдэгдэж мэргэжлийн талаас туслах.
3	Суртал, мэргэжлийн ангийн бэлэн байдал хариуцсан туслах.	ТХАБЭА-н инженер	Гал унтраах ангийн машин техниккийн усан хангамжийг цэнгэлтэх III-т хөөсрүүлэх системээр галыг унтраах ажлыг удирдан зохино байгуулах.	Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал галын аюулгүйн дүрэм заавар хэрхэн хэрэгжиж байгааг хяналт тавих.
4	Байгууллагын тогтвортой ажиглалтаа, Хэв журам, эд хөрөнгө хамгаалах асуудал хариуцсан туслах. ТСДБ –н гишүүн.	ДХХХА-ны дарга Хариул Жолооч	Гал гарсан даргид байгууллагын эд хөрөнгө, тоног төхөөрөмжийг нүүлгэн шилжүүлэх үед хульгайн халдлага гарвал 7035102 утсаар мэдэгдэж хамгаалах ажлыг удирдан зохион байгуулах.	Хариул хамгаалалтын байгууллагтай хамтарч ажиглах болон нүүлгэн шилжүүлэлтийн ажлын явц хэрхэн хэрэгжиж байгааг хяналт тавих.
5	Хүн эмнэлгийн үйлчилгээ хариуцсан туслах. ТСДБ –н гишүүн.	Нягтлан Лаборантууд Тогооч Үйлчилгэгч	Галын аюулаас эрсдэлт орсон ажилчин албан хаагчдад эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулах 7035103 утсаар мэдэгдэж дуудлага өгөх, утгаж авах ажлыг зохион байгуулана.	ТХАБЭА-н инженертай хамтарч ажиглах өрсөн үүрэг даалгаварыг биелүүлэх.
6	Хүн эмнэлгийн үйлчилгээ хариуцсан туслах. ТСДБ –н гишүүн.	Нягтлан Лаборантууд Тогооч Үйлчилгэгч	ДХХХА-ны даргад гамшгийн үед эд хөрөнгөд үүсэж болзошгүй нөхцөл байдалыг мэдэгдэж хамтарч ажиглах	ТХАБЭА-н инженертай хамтарч ажиглах өрсөн үүрэг даалгаварыг биелүүлэх.
7	Аж ахуй хангалт хариуцсан туслах	Аж ахуйн Агуулахын нярав	Мэдэгдэж хамтарч ажиглах	ТХАБЭА-н инженертай хамтарч ажиглах өрсөн үүрэг даалгаварыг биелүүлэх.

8	Аврах гал унтраах бүлэгийн гишүүд	Товарын операторууд	Галын шлангийг дэлгэн хооронд нь холбон модулийн усны насосноос гадна галын улаан шугамд хөөсний генераторыг залгаж бойлерын дотуур краныг ашиглан гал унтраах үйл ажиллагааг явуулна.	Галын хөөсний генераторын байнгын ажиллагаанд хяналт тавьж, ажиллах зарчмыг сайтар мэддэг байх, өөрийн хариуцсан хэсэг дээр галын аюулгүйн дүрэм, зааварыг мөрдлөгө болгон ажиллах.
9	Цахилгаан дулаан сантехник, аваарын бүлэгийн гишүүд	Технологийн операторууд	Гал гарсан үед тухайн гал гарсан хэсгийн цахилгаан гүйдлийг таслахад туслах гал унтраагууруудыг ажиллууж гал унтраахад оролцоно.	Штабын дарга болон Холбоо зарлан мэдээлэл, сурталчилгаа хариуцсан туслахад илэрсэн зөрчил дутагдлын талаар дор бүр нь мэдээллэх.

ГАЛ ТҮЙМЭР ГАРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛТЭЙ ГАЗАР, ХЭСГҮҮД

УЧРАХ ХОХИРЛЫН ТООЦОО

№	Гал түймэр гарч болзошгүй хэсэг	Шалтгаан	Учрах хохирол
1	СНП-50М модуль	Цахилгаан, ил гал, аянга цахилгаан, оч	1,0 сая \$
2	Босоо резервуар	Ил гал, аянга цахилгаан, оч	Хадгалагдаж буй нефть бүтээгдэхүүн, сав тоног төхөөрөмжийн эвдрэл
3	Хэвтээ резервуар	Ил гал, аянга цахилгаан, оч	Хадгалагдаж буй нефть бүтээгдэхүүн, сав тоног төхөөрөмжийн эвдрэл.
4	Авто эстакад	Цахилгаан, ил гал, аянга цахилгаан, оч	Нефть бүтээгдэхүүн, түгээгүүр, тоног төхөөрөмж барилга байгууламж эвдрэх нурах.
5	Вагон эстакад	Цахилгаан, ил гал, аянга цахилгаан, оч	Нефть бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, барилга байгууламж эвдрэх нурах.

ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ ХҮЧ ХЭРЭГСЭЛ

№	Багаж, техник хэрэгсэл	ГСДБ-н гишүүдийн тоо	Хариуцах ГСДБ-н гишүүн	Албан тушаал
1	Ус, хөөсний насос	2	Аврах гал унтраах бүлэгийн гишүүд	Талбайн мастер ахлах оператор
2	Галын гидрант	2	Аврах гал унтраах бүлэгийн гишүүд	Ахлах оператор, товарын оператор
3	Ханын кран	4	Аврах гал унтраах бүлэгийн гишүүд	Агуулахын эрхлэгч, товарын операторууд
4	ОУ-80галын унтраагуур	2	Сургалт, мэргэжлийн ангийн бэлэн байдал хариуцсан туслах	ГХАБЭА-н инженер Технологийн оператор
5	Нунтаг хор	6	Аврах гал унтраах бүлэгийн гишүүд	Товарын операторууд Технологийн операторууд Гагнуурчин засварчин
6	Галын шит	6	Цахилгаан дулаан, сантехник, аваарын бүлэгийн гишүүд	НБҮ-н дарга технологийн операторууд, Инженер

АВРАХ, ГАЛ УНТРААХ БҮЛГИЙН СУДАЛГАА, ХОЛБОО БАРИХ НӨХЦӨЛ Хавсралт 02

№	Овог нэр Албан тушаал	Хүйс	Томилгоо хариуцах багаж хэрэгсэл	Гэрийн хаяга	Холбоо барих утас
1	Саваськов Б.Н НБУ-н дарга	Эр	Галын унтраагуур, эсгий хүрз,элс галын шит ашиглах	Хүрэн булаг баг 4-14-41 тоот	99552354 70357831
2	О. Мөнх-Эрдэнэ ДХХХА-ны дарга	Эр	Галын унтраагуур, эсгий хүрз,элс ашиглах	Хүрэн булаг баг 4-25-06 тоот	99231101
3	Н. Дашням Ашиглалт инженер	Эр	Галын унтраагуур, эсгий хүрз,элс галын шит, кран ашиглах	Урт булаг баг 5-10-25 тоот	94034223 89828917
4	А. Баярсайхан Цахилгаан инженер	Эр	Галын унтраагуур, эсгий хүрз, элс галын гидрант ашиглах	Хүрэн булаг баг 4-14-81 тоот	99685118 95555660
5	Д. Батцэцэг Нягтлан	Эм	Галын унтраагуур, эсгий хүрз,элс ашиглах	Уртын гол Баянтал 3-98тоот	95004458
6	Т. Эрдэнэчимэг Нарийн бичиг	Эм	Галын унтраагуур, эсгий хүрз,элс ашиглах	Уурхайчин баг 3-16-60 тоот	99907214 99362133
7	Ч. Ууган баяр Талбайн мастер	Эр	Ус, хөөсний насос галын шланга хошуу баригч.	Наранбаг 32-3 тоот	99360982 88360982
8	Г. Эрдэнэбаатар Агуулахын эрхэлгч	Эр	Ус, хөөсний насос галын шланга холбогч, залгагч галын унтраагуур	Баян цагаан баг шинэ хороолол 27-1 тоот	99856346 94156753
9	Д. Өнөболд Агуулахын эрхэлгч	Эр	Ус, хөөсний насос галын шланга хошуу баригч.галын унтраагуур	Зэст 1-19-29	86033086 88033086
10	Д. Уламнэмэх Нярав	Эр	Галын унтраагуур, эсгий хүрз,элс ашиглах	Шанд баг 24-26 тоот	95350274 94354879
11	Ц. Түмэннасан Ахлах оператор	Эр	Галын унтраагуур, эсгий хүрз,элс галын шит ашиглах	Наран баг 27-13 тоот	99558632 99408607
12	П. Энхбаатар Ахлах оператор	Эр	Галын унтраагуур, эсгий хүрз,элс галын шит ашиглах	Шанд баг 24-26 тоот	95350274 88386915
13	Ч. Бөхбат Технологи оператор	Эр	Галын унтраагуур, эсгий хүрз,элс галын гидрант	Согоот баг 6-12-85	95715151 99353557
14	М. Сүрэнхүү Товарын оператор	Эр	Галын унтраагуур, эсгий хүрз,элс галын шит ашиглах	Их залуу баг хабитат 66-10	95777583 99551877
15	М. Өнөрболд Товарын оператор	Эр	Галын унтраагуур, эсгий хүрз,элс галын кран ашиглах	Хүрэн булаг баг 4-25-06	85955627
16	Н. Бат-Эрдэнэ Гагнуурчин	Эр	Галын унтраагуур, эсгий хүрз,элс галын кран ашиглах	Эрдэнэ баг 20-7 тоот	99350261 99360039
17	Б. Тамир Товарын оператор	Эр	Галын унтраагуур, эсгий хүрз,элс галын кран, шит ашиглах	Наран баг арван цагаан 40-10-2 тоот	99750651 99891706
18	Д. Алтан тамир Жолооч	Эр	Галын унтраагуур, эсгий хүрз,элс галын кран ашиглах	Хүрэн булаг баг 4-18-90 тоот	99354171 99061443
19	О. Энх зул Лаборант	Эм	Галын унтраагуур, эсгий хүрз,элс ашиглах	Их залуу баг хабитат 19-14 тоот	99358323
20	А. Бадмаараг Лаборант	Эм	Галын унтраагуур, эсгий хүрз,элс ашиглах	Яргуйт баг 9а-7 тоот	95961995
21	Э. Аззаяа Лаборант	Эм	Галын унтраагуур, эсгий хүрз,элс ашиглах	Урт булаг баг 5-23-34	99354328
22	М. Оюунтуяа Тогооч	Эм	Галын унтраагуур, эсгий хүрз,элс ашиглах	Урт булаг баг 5-3-57	99359079
23	Г. Ганчимэг Үйлчлэгч	Эм	Галын унтраагуур, эсгий хүрз,элс ашиглах	Баян-зам 10-6 тоот	99557773 99341556

**ГАЛ ТҮЙМРИЙН АЮУЛТАЙ БҮСЭЭС ХҮН БОЛОН ЭД ХӨРӨНГИЙГ
НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ТООЦОО**

№	Галд өртөх хэсэг, хүн ам эд хөрөнгө	Нүүлгэн шилжүүлэх газар	Ямар аргаар		Хугацаа
			Явганаар	Тээвэрийн хэрэгсэлээр	
1	Үйлдвэрийн барилга байгууламж			+	8 цаг
2	Бүх ажилчид	“Орхон хийц” ХХК	+	+	1 цаг

**НЕФТЬ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙГ ГАМШИГ, ГАЛ ТҮЙМЭРИЙН
ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ ҮҮДНЭЭС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН
ТӨЛӨВЛӨГӨӨ**


№	Хийхээр төлөвлөж буй ажил	Төлөвгөөт ажлын үргэжлэх хугацаа	Хариуцан гүйцэтгэгч
1	Штабын гишүүдийн ажил хуваарь гарган албаны даргаар баталгаажуулан хэрэгжилтэнд хяналт тавих.	1-р сард	Ерөнхий инженер
2	Дулаан, цахилгаан, сантехникийн шугамын гэмтлийг тогтоон зөрчилгүй болгох.	2-р сард	Ерөнхий инженер технологийн операторууд
3	Нефть боловсруулах үйлдвэрийн агуулах эмх цэгц хөрөнгийн бүртгэлд үзлэг хийх.	1-р сард	ДХХХА-ны дарга Нярав
4	Шинээр авсан эд материалыг үндсэн хөрөнгөнд бүртгэн данслах	1-р сард	Нягтлан бодогч Нярав
5	Агуулах болон СНП-50М модуль дээр гамшиг ослын үед ажиллах ажил үүргийн хуваарь, томилогоог хийлгүүлж, дадлага сургуулийг зохион байгуулах.	4-р сард	ГХАБЭА –н инженер Бүх ажилчид
6	Галын хор шинээр авч, элс бэлтгэх галын булан, схем зураглал гаргах. Ус алдалт хөлдөлтөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт хийж дадлагжуулах.	2-р сард	ГХАБЭА –н инженер Ашиглалтын инженер
7	Өмч хамгаалалын булан гаргах	2-р сард	ДХХХА-ны дарга Нярав
8	Штабын хурлаар нефть боловсруулах үйлдвэр болон шатах тослох материалын агуулах баазын эрсдэлээс сэргийлэх ажлыг	3-р сард	ГСДБ –н гишүүд

	авч хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудалыг авч хэлцэн шийдвэрлэх.		
9	Холбоо зарлан мэдээлэл, сурталчилгаа, сургалт зохион байгуулах. Гамшиг гал түймэрийн үед нүүлгэн шилжүүлэх, Хулгай болон троресст халдлагаас хэрхэн сэргийлэх тухай сургалт зохион байгуулах.	4-р сард	Цахилгааны инженер ДХХХА-ны дарга Нярав
10	Гамшиг, гал түймэрийн үед ГСДБ –н гишүүд хэрхэн сэтгэл зүйн бэлэн байдалд байх талаар сургалт зохион байгуулах. Багаж хэрэгсэлийг хэрхэн зөв хэрэглэх иргэний хамгааллын сургалт зохион байгуулах.	5-р сард	Цахилгааны инженер ГХАБЭА-н инженер
11	Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар ажилчин албан хаагчдын дунд сургалт зохион байгуулан дадлагжуулах.	6-р сард	Ашиглалтын инженер ГХАБЭА-н инженер

3.2. Судалгааны ажил


Объектын гал түймрээс шалтгаалсан хохирол

\сүүлийн 7 жилээр\




Байгууллагын тоног төхөөрөмжийн хохирол хувиар






Бэртэж гэмтсэн болон нас барсан хүний тоо \сүүлийн 7 жил/




Аюулт үзэгдлийн тохиолдлоор нь авч үзвэл \сүүлийн 7 жилээр\



Судалгаа нь:


Лаборонт, насосны станц болон ачиж буулгах байгууламж гэх мэт нефть, бензинтэй шууд харьцаж ажилладаг 17-н ажилчидаас авсан судалгаа юм.

Байгууллагын удирдах албаны хэсэг ороогүй болно. Судалгаанаас харахад:

Судалгаа 1:

Судалгаа 1-ийг харахад нефть бензинтэй шууд харьцдаг ажилчидийн 1-5 жил буюу А хариултыг сонгосон 3 ажилчин, Б хариулт буюу 6-10 жил ажилсан 10 ажилчин, В буюу 10-аас дээш жил ажилсан 4 ажилчин тус тус сонгосон. Ажилчидын 82% буюу 14 ажилчин ажлын өндөр туршлагатай нь харагдаж байна.

Судалгаа 2:



Судалгаа 2-г харахад 88% буюу 15 ажилчин тийм гэсэн хариулт өгч үлдсэн 12% буюу 2 хүн буюу тогооч болон тогоочийн туслах нар сургалт хийсэн ч суудаггүй гэж хариулав. Учир нь: Сургалтанд суувал ажилчидын хоолны цаг хойшлогдож их удах болно гэсэн хариулт өгөв

Судалгаа 3:

Энэхүү судалгааг байгуулгын цахилгааны инженертэй ярилцсан болно.


Энэхүү байгууллага нь цахилгаан хувийн хамгаалах хэрэгсэлээр хангадаг боловч цаг тухай бүрт хангалтыг тавьж өгдөггүй.

Судалгаа 4:



Судалгаа 4-г харахад нефть бензинтэй шууд харьцдаг ажилчидийн 88% буюу 15 ажилчин тийм гэсэн хариулт өгч үгүй гэсэн хариултыг 12% буюу 2 ажилчин сонгосон нь тогооч юм.

Судалгаа 5:



Судалгаа 5-г харахад лаборант, насосны станц болон резервуарын парк гэх хэсэгүүдэд галын зааварчилга байдаг ба хамгийн их ажилчин ажилдаг хэсэг буюу ачиж буулгах байгууламжийн хэсэгт галын зааварчилга байдаггүй.

Энэхүү судалгааг харахад байгууллагын нефть бензинтэй шууд харьцдаг ажилчид идвэхи оролцоотой ба бие даах чадвар болон багаар ажиллах чадвар сайн нь харагдаж байна.

Галын аюулгүй байдлыг ханган ажиллахын тулд дараах ажилуудыг хийх шаардлагтай гэж үзэж зөвлөх нь:

- Ижил төстэй гадаадын байгууллагаас туршлага судлах.
- ОУ-ын байгууллагуудын жишгийг судлан түүнд түшиглэн бодлого боловсруулах.
- Эдгээр хуулийн заалтын дагуу сургалтыг үр дүнтэй хийх.

Галын үзүүлэх сургалтыг жилд 1-ээс багагүй удаа зохион байгуулж нийт иргэд ажилтануудыг гал гарсан үед авах арга хэмжээнд суралцуулж дадлагтай болгох нь чухал мөн галын хорыг сайн ашиглаж чаддаг байх ёстой.

- Мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэй байгууллагатай хамтарч ажиллах.
- Гал унтраах болон утаа эсэргүүцэх, утаанаас хамгаалах автомат систем байршуулна.
- Гал унтраах ажиллагаанд оролцож байгаа ажилчдыг шаардлагатай хамгаалах хэрэгслээр хангаж, аюулгүй ажиллагааны заавар өгч, хяналт тавина.
- ОБА-ны гал унтраах ангийг угтан авах.
- галын голомт руу хамгийн богино чиглэлээр очих замыг зааж өгөх хүнийг томилж гаргана.
- ОБА-ны гал унтраах анги ирсэн үед гал унтраах үйл ажиллагааны удирдлагыг гал унтраах удирдагчид шилжүүлж түүнд объект дотор хүн байгаа эсэх, объектийн барилга байгууламжийн хийц бүтээц, аврах зам гарц, усан хангамж, технологи, үйл ажиллагааны онцлог, хэрэглэж, хадгалагдаж байгаа бодис материал төрөл хэмжээ, тэдгээрийн байршил ба галын болон тэсрэх шинж чанар, тэсэрч дэлбэрэх болон цацраг идэвхит бодис материал байгаа эсэх, галыг хязгаарлан унтраахад авсан арга хэмжээ, унтраах ажиллагаагаар объект дээр ажиллаж буй хүн хүч болон шаардлагатай бусад мэдээллийг дэлгэрэнгүй өгнө. Мөн гал унтраах ажиллагаанд шаардагдах машин, техник хэрэгсэл, хүн хүч, холбооны болон бусад хэрэгслийг гаргаж өгөхөөс гадна бүхий л төрлийн

Дүгнэлт

“Петролеум Прадакшн” ХХК-н ХАБ,ЭА-н ажлын үзүүлэлт мөн галын аюулгүй байдлыг хангах талаар хийгдэх ажлыг тодорхой болгох үүднээс энэхүү судалгааг хийлээ.

Судалгааны явцад илэрсэн байгууллагын давуу тал:

- Ажилчдын идвэхитэй оролцоо
- Байгууллагын нийт ихэнх ажилчид ажлын өндөр туршлагатай
- ХАБ,ЭА-н ажилтан чадварлаг
- Байгууллагын ажилчид багаар ажиллах чадвар сайтай
- Байгууллагын ажилчид бие даах чадвар сайн

Судалгааны явцад илэрсэн байгууллагын алдаа дутагдал:


- Галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалтыг дутуу хайнга хийсэн
- Галын хор тоноглолд мөнгө санхүү төсөв батлаж ажилладагүй.
- Галын хор тоноглолыг худалдан авах ажил хийгддэггүй
- Цахилгааны аюулгүй байдлын гүйцэтгэл дутмаг
- ХАБЭА-н хууль болон Галын тухай хуулийг зөрчиж байгаа нь хамгийн том зөрчил буюу гал гарах шалтгаан болж байна гэж үзлээ.

Тиймээс цаашид хийх ажилыг галын аюулгүй байдлыг хангахын тулд хийх шаардлагтай ажилууд болгон зөвлөмжинд тусгав.

Эдгээр ажлуудыг ажлын төлөвлөгөө гарган хийвэл “Петролеум Прадакшн” ХХК-н ХАБЭА бодлого дахь галын аюулгүй байдалын зөрчил дутагдал, эрсдэл нь эрс багасна гэдэгт найдаж байна.


Хавсралт

ГАЛ ТҮЙМЭР ГАРСАН ҮЕД ЭД ХӨРӨНГИЙГ ЗӨӨВӨРЛӨХ, ХҮМҮҮСИЙГ АВРАХ СХЕМ НАСОСНЫ СТАНЦИ



ГАЛ ТҮЙМЭР ГАРСАН ҮЕД ЭД ХӨРӨНГИЙГ ЗӨӨВӨРЛӨХ, ХҮМУУСИЙГ АВРАХ СХЕМ

ТЕХНОЛОГИЙН БАЙР



ГАЛ ТҮЙМЭР ГАРСАН ҮЕД ЭД ХӨРӨНГИЙГ ЗӨӨВӨРЛӨХ, ХҮМУУСИЙГ АВРАХ СХЕМ 3-Н ДАВХАР КОНТАРЫН БАЙР

